

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ 03 САРЫН
ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА**

Эрдэнэт хот

2017 он

1.Макро эдийн засаг



Төсөв санхүү

Аймгийн төсөвт 21.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 113.1 хувьтай байна. Татварын орлого 27.5 хувиар давж биелсэн бол татварын бус орлого 2.0 хувиар тасарсан байна.

Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 52.8 хувийг буюу 14.7 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 4.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 9.2 хувийг хөрөнгийн зардалд, 19.4 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 24.3 хувийг бараа үйлчилгээний зардалд, 42.6 хувийг цалин хөлсөнд зарцуулжээ.

Салбарын хувьд эдийн засгийн бусад салбарт 0.7 хувийг, эрүүл мэнд, амралт спортын салбарт 2.7 хувийг, ангилагдаагүй бусад зардалд 9.2 хувийг, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн салбарт 17.9 хувийг, нийтийн ерөнхий үйлчилгээнд 24.4 хувийг, боловсрол соёл урлагийн салбарт 45.0 хувийг зарцуулсан байна.

Өмнөх оны мөн үеэс нийт зарлага санхүүжилт 14.9 хувиар бага, харин төсвийн орлого 7.8 хувиар их байна.



Банк, мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 362.2 тэрбум төгрөгийг гүйлгээнээс татаж, 375.9 тэрбум төгрөгийг гүйлгээнд гаргасан байна. Өмнөх оны мөн үеэс гүйлгээнээс татсан төгрөгийн хэмжээ 6.5 хувиар, гүйлгээнд гаргасан төгрөгийн хэмжээ 7.6 хувиар өссөн байна.

Иргэдийн хувийн мөнгөн хадгаламж 186.5 тэрбум төгрөг болж, аймгийн нэг хүнд дунджаар 1830160 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 1652914 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үеэс хадгаламжийн үлдэгдэл 27.3 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 6.9 хувиар өсчээ.

Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн сарын хүү 0.48-0.6 хувь, хугацаатай хадгаламжийн сарын хүү 0.7-1.4 хувь, харин хугацааны эцэст зарласан зээлийн сарын хүү 0.42-2.6 хувь байна.

Арилжааны банкуудын дүнгээр 231.5 тэрбум төгрөгийн зээлийг 18.7 мянган иргэд, аж ахуйн нэгжид олгожээ. Өмнөх оны мөн үеэс зээлжигчийн тоо 9.8 хувиар, олгосон зээлийн хэмжээ 5.1 дахин тус тус өссөн байна.

Банк бус санхүүгийн 2 байгууллага, 9 хадгаламж зээлийн хоршоод 531 хадгаламж эзэмшигчийн 2.5 тэрбум төгрөгийн хадгаламжийг төвлөрүүлж, 803 иргэд, аж ахуйн нэгжид 2.1 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Өмнөх оны мөн үеэс олгосон зээлийн хэмжээ 59.9 хувиар, хадгаламж 20.7 хувиар, зээлжигчийн тоо 21.5 хувиар өсчээ.



Үнэ

Хэрэглээний үнэ тарифын судалгааг хэрэглээний сагс дахь 213 нэр төрлийн бараа үйлчилгээнд хийв. Судалгааны дүнгээр үнийн ерөнхий индекс энэ сард 100.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар, 2016 оны жилийн эцсийн байдлаас 2.5 хувиар өссөн байна.

Өмнөх сараас бусад бараа, үйлчилгээ, хүнсний барааны бүлгийн индекс 0.1-0.9 хувиар өсч, хувцас, бөс бараа, гэр ахуйн бараа бүлгийн индекс 0.5-0.1 хувиар буурсан бол бусад бүлгийн хувьд үнэ тогтвортой байна.

Хүнсний барааны бүлгийн үнийн индексийн өсөлтөнд малын махны 1 кг-ын үнэ 200-1100 төгрөгөөр, манжин, байцаа 200-500 төгрөгөөр, өндөг 20 төгрөгөөр, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнийн индексийн өсөлтөнд гар нүүрийн саван 20 төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Хувцас, бөс бараа бүлгийн индексийн бууралтанд торго 700 төгрөгөөр, эрэгтэй хүний хавар намрын хүрэм 3000 төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.



Гадаад худалдаа

Аймгийн хэмжээнд гадаад худалдаагаар 524.6 тэрбум төгрөг буюу 211.9 сая ам долларын бараа эргэлт хийсэн байна. Өмнөх оны мөн үеэс нийт эргэлт 43.3 хувиар өссөнөөс экспорт 54.6 хувиар өсч, харин импорт 24.1 хувиар буурсан байна.

Гадаад худалдаагаар гол нэрийн бүтээгдэхүүнээс 160.5 мян.тн зэсийн баяжмал, 4.1 мян.тн катодын зэс, 1.7 мян.тн молибдены баяжмал, 5.7 мян.м2 хивс зэрэг 484.8 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн экспортлож, тээрмийн ган бөмбөлөг 1.4 мян.тн, бензин 4.1 мян.тн, дизелийн түлш 6.6 мян.тн зэрэг нийт дүнгээр 39.9 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн импортоор авчээ.

Өмнөх оны мөн үеэс экспортолсон катодын зэс 17.1 хувиар, молибдений баяжмал 13.3 хувиар, зэсийн баяжмал 1.3 хувиар, импортолсон дизелийн түлш 2.6 дахин нэмэгдэж, экспортолсон хивс 47.7 хувиар, импортолсон бензин 16.3 хувиар, тээрмийн ган бөмбөлөг 1,6 дахин буурсан байна.



Хөдөлмөр эрхлэлт

Тайлант хугацаанд 98 хүн ажилд орсноос 12.2 хувь буюу 12 нь шинээр бий болсон ажлын байр байна. Нийт бий болсон ажлын байрны 6.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлд, 9.2 хувь нь худалдааны салбарт, 12.2 хувь нь санхүүгийн болон даатгалын салбарт, 24.5 хувь нь эрүүл мэнд ба боловсролын үйл ажиллагааны салбарт ажилд орсон нь дийлэнх хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1751 хүн бүртгэлтэй байгаагийн 55.2 хувь нь эмэгтэйчүүд ба бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар буюу 671 хүнээр бага байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 16.0 хувь нь 15-24 насныхан, 19.5 хувь нь 45-60 насныхан, 22.3 хувь нь 35-44 насныхан, 42.2 хувь нь 25-34 насныхан байна.

Бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 22.2 хувь нь сургууль төгссөн, 18.9 хувь нь орон тооны цомхотгол, 10.4 хувь нь өөр газраас шилжиж ирсэн, 3.3 хувь нь байгууллага татан буугдсан шалтгаанаар ажил хайж бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийн 45.9 хувийг бүрэн дунд, 37.5 хувийг дээд, 7.7 хувийг мэргэжлийн анхан шатны, 5.3 хувийг тусгай дунд, 2.7 хувийг суурь, 0.6 хувийг бага боловсролтой, 0.3 хувийг боловсролгүй хүмүүс эзэлж байна.

2. Нийгмийн үзүүлэлт



Хүн амын хөдөлгөөн

Оны эхний 3 сард шинээр төрсөн 469 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 96 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 129 гэрлэлтийг бүртгэн, 40 гэрлэлтийг цуцалж, 16 хүүхэд үрчлэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс, нас баралт 35.1 хувиар, төрөлт 16.5 хувиар, гэрлэлт 25.9 хувиар, цуцлалт 21.6 хувиар буурч, үрчлэлт 45.5 хувиар нэмэгджээ.

УБХ-ийн мэдээгээр тайлант хугацаанд 689 хүн шилжин явж, 678 хүн шилжин иржээ. Шилжин ирэгсдийн 33.0 хувь нь Улаанбаатар хотоос, 24.9 хувь нь Булган аймгаас шилжин ирсэн нь дийлэнх хувийг эзэлж байна. Насны хувьд шилжин ирэгсдийн 65.6 хувь нь 15-54 насныхан байна. Шилжин явагсдын 45.6 хувь нь Улаанбаатар хот руу шилжин явжээ.



Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 151.5 мянган хүнд үзлэг хийснээс 31.0 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 3.8 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 3.0 хувиар нэмэгджээ.

Сэргийлэх тарилгад 4.1 мянган хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүний 98.3 хувь нь бөгөөд өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 542 эх амаржин, 122 хүн нас баржээ. Нас баралтын 2.5 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 12.4 промилээр, 1000 хүнд ногдох төрөлт 1.2 промилээр, нас баралт 0.3 промилээр буурчээ.

Халдварт өвчнөөр өвчилсөн 128 тохиолдол гарсан нь өмнөх оны мөн үеэс 75.0 хувиар буюу 41.9 продицимилээр буурсан байна. Нийт өвчлөлтийн 3.9 хувийг цусан суулга, 5.5 хувийг халдварт шар, 5,5 хувийг салхинцэцэг, 6.3 хувийг гар, хөл, амны өвчин, 11.7 хувийг сүрьеэ, 18.8 хувийг мөөгөнцөр, 44.5 хувийг бэлгийн замын халдварт өвчин, үүний 43.8 хувийг тэмбүүгээр, 47.4 хувийг трихоманазаар, 8.8 хувийг заг хүйтнээр өвчлөгсөд эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс 10000 хүнд ногдох гар, хөл, амны өвчин 0.2, цусан суулга 0.3, заг хүйтэн 0.3, халдварт шар 0.5, салхинцэцэг 0.5 продицимилээр нэмэгдэж, бусад халдварт өвчний гаралт 0.3-1.4 продицимилээр буурсанаас тэмбүү 1.4 продицимилээр буурчээ.

Өмнөх оны мөн үед гарч байгаагүй хамуугаар өвчилсөн 1, суулгалт халдвараар өвчилсөн 2, бүслүүр үлдээр өвчилсөн 2 тохиолдол гарчээ. Харин өмнөх оны мөн үед гарч байсан улаан бурхан, улаанууд, улаан эсэргэнээр өвчилсөн тохиолдол гараагүй байна.



Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 186 хэрэгт 184 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 65.1 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс бүртгэгдсэн хэрэг 21.6 хувиар, холбогдогч 49.6 хувиар, хэргийн илрүүлэлт 2.6 пунктээр, 18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 3.2 продицимилээр нэмэгджээ.

Нийт бүртгэгдсэн хэргийн 44.6 хувь нь согтуугаар үйлдэгдсэн, 33.9 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй, 10.2 хувь нь хүнд, онц хүнд хэрэг байгаа ба өмнөх оны мөн үеэс хүнд, онц хүнд хэрэг 18.8 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25.8 хувиар, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 31.3 хувиар нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл нийт хэргийн 40.3 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, 30.1 хувийг хулгайн хэрэг, 4.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, 4.3 хувийг залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх хэрэг, 3.8 хувийг танхайрах, 2.2 хувийг хүчин, 2.2 хувийг бусдын эд хөрөнгө дээрэмдэх хэрэг эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг 18.1 хувиар, залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх хэрэг 38.5 хувиар, хүчингийн хэрэг 42.9 хувиар буурч, хүнийг санаатай алах хэрэг мөн үеийн түвшинд байж, бусад хэргийн гаралт 23.0%-7.0 дахин нэмэгдсэнээс танхайрах хэрэг 7.0 дахин нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэдэд 351.2 сая төгрөгийн хохирол учирч, 4 хүн нас барж, 95 хүн гэмтсэн ба нийт хохирлын 29.1 хувийг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт холбогдсон 184 хүний 57.1 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 48.9 хувь нь согтуугаар, 25.5 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн ба 6.0 хувь нь 18 хүртэл насны хүүхэд байна.

Хэв журмын нөхцөл байдлын хувьд 1671 хүн эрүүлжигдэн, 97 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс баривчлагдсан хүний тоо 7.6 хувиар буурч, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 45.1 хувиар нэмэгджээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 266 жолоочийг илрүүлэн, 241 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оны мөн үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 16.6 хувиар, эрх хасалт 9.7 хувиар бага байна.



Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 38.0 мянган хүнд 17.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 1.7 мянган хүнд 679.5 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1.8 мянган хүнд 326.7 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 1.7 мянган хүнд 224.9 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 4.2 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 102.5 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 11.5 мянган хүнд 1.3 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт олгожээ. Өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 22.6 хувиар олгосон халамжийн хэмжээ 12.1 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгаас 70-аас дээш насны 2.7 мянган ахмад настанд 32.5 сая төгрөгийн сар шинийн хүндэтгэл, 30 иргэнд 5.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, орон нутгийн халамжийн сангаас үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 20.9 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 15.3 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 6.8 хувиар давж биелсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 5.0 хувиар тасарч, бусад сангийн орлого 5.9 - 38.2 хувиар давж биелжээ. Сангийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар их байна.

Тайлант хугацаанд 404 хүнд шинээр тэтгэвэр тогтоосноос 63.4 хувьд нь өндөр насны, 32.9 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.7 хувьд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоожээ. Тэтгэвэр тогтоолгосон хүний тоо өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар их байна.

Эрүүл мэндийн даатгалд даатгуулагч 71.6 мянган хүний 61.8 хувь нь төр төлбөрийг нь даадаг, 38.2 хувь нь заавал даатгуулагсад байна. Өмнөх оноос эрүүл мэндийн даатгалд даатгуулагч 0.7 хувиар буурч, тэтгэврийн нэрийн данс нээлгэсэн хүний тоо 2.2 хувиар нэмэгджээ.

3. Үйлдвэрлэл үйлчилгээ.



Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 487.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 526.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 66.5 хувиар, борлуулалт 72.4 хувиар нэмэгдсэн байна. 2005 оны зэрэгцүүлэх үнээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 1.7 хувиар өсчээ.

Нийт бүтээгдэхүүний 99.97 хувь нь Баян-Өндөр суманд, 0.03 хувь нь Жаргалант суманд үйлдвэрлэгджээ.

Өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 3.5 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 7.9 хувиар, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 73.7 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүний 93.1 хувийг уул уурхайн олборлох, 4.7 хувийг боловсруулах, 2.2 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 66.7 хувийг төмрийн үйлдвэрлэл, 19.6 хувийг ноосон нэхмэлийн үйлдвэрлэл, 7.4 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 4.3 хувийг оёдол, 1.7 хувийг тавилга үйлдвэрлэл, 0.9 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 0.3 хувийг цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл, 0.2 хувийг хэвлэх үйлдвэрлэл, 0.2 хувийг резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 0.1 хувийг хоёрдогч түүхий эд бэлтгэл, 0.1 хувийг ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, 0.03 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл эзлэж байна.

Хүнсний бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийн 40.8 хувь нь хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 33.8 хувь нь гурил, тэжээлийн үйлдвэрлэлт, 14.0 хувь нь мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 10.5 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.9 хувь нь архи, ундаа үйлдвэрлэлт байна.

Гол нэр төрлийн 57 бүтээгдэхүүнийг судалгаанд хамруулснаас дулаан эрчим хүч, лед чийдэн, оёмол хөнжил, гоймон, хүчилтөрөгч, монгол эм, хүүхдийн гутал, хивс, цахилгаан эрчим хүч, молибдений баяжмал, хүснэгт маягт, ажлын хувцас, сонин, зэсийн баяжмал, банш, бууз, хуушуур, ном, вакуум хаалга, цонх, хиам 1.4-72.5 хувиар, хөшиг, буриад гутал, барилгын хаалга цонх, амтат ус ундаа, эсгий, ноосон хөнжил, боловсруулсан шингэн сүү, дайвар бүтээгдэхүүн, хэвийн боов, шавардлагын зуурмаг, зайрмаг, гудас 2.3-28.1 дахин өсч, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1.7-95.5 хувиар буурсаны дотор ноолууран алчуур нөмрөг үйлдвэрлэл 95.5 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 12.3 хувиар буурч, хөдөлмөрийн бүтээмж 89.7 хувиар өсчээ.

Энэ улиралд хэвлэлийн “Мэргэн гүүш” ХХК, цэвэр ус үйлдвэрлэлийн “Их билэгдэй” ХХК, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Нившээл” ХХК-ийг шинээр статистикт нэмж хамрууллаа.



Хөдөө аж ахуй

Оны эхний төллөх эх малын 8.6 хувь буюу 5.2 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 95.2 хувь нь бойжиж байна. Өмнөх оны мөн үеэс төллөлт 1.9 пунктээр буурч, төлийн хорогдол 7 дахин их байна.

2308 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 98.3 хувьтай байна. Мал онд оролт өмнөх оноос 1.5 пунктээр бага, малын хорогдол 9.2 дахин өссөн байна. Нийт хорогдсон малын 76.0 хувь нь бог мал бөгөөд үүний дийлэнх нь хонь байна.

Баян-Өндөр сумын төллөх эх малын 17.0 хувь, Жаргалант сумын төллөх эх малын 5.3 хувь нь төллөж, гарсан төлийн 93.0-96.4 хувь нь бойжиж байна.

Жаргалант суманд 1473 толгой том мал зүй бусаар хорогдсон нь аймгийн нийт хорогдлын 63.8 хувийг эзэлж байна.

Аймгийн мал эмнэлэгийн байгууллагууд 44.9 мян.толгой малд үзлэг, 3.2 мянган толгой малд туулгалт хийж, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 28.3 мянган малыг хамруулсан байна. Өмнөх оноос үзлэгт хамруулсан мал 60.9 хувиар, туулгалт хийсэн мал 3.5 дахин өсчээ. Паразит өвчнөөр 16.4 мянган мал өвчилсөн байна.

Халдварт өвнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хийгдээгүй байгаа шалтгааныг аймгийн ХХААГ хугацаа болоогүй хэмээн тайлбарлаж байна.



Барилга

Их барилгын 1 аж ахуйн нэгж 1.2 тэрбум.төгрөгийг барилга угсралт, их засварын ажлыг 3 объектод хийж гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар багасчээ.



Тээвэр, холбоо

Тээврийн байгууллагууд 34.2 мянган тн ачаа тээвэрлэн, 12.2 сая тн/км-ийн ачаа эргэлт, 1.1 сая зорчигч тээвэрлэн, 23.9 сая хүн/км-ийн зорчигч эргэлт хийж, тээврийн үйлчилгээнээс 4.0 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 3.0 хувиар, зорчигч эргэлт 0.7 хувиар өсчээ. Зорчигч тээврийн үйлчилгээнд 489 такси, 30 микроавтобус, 58 автобус гарч тэдгээрт 837 хүн ажиллаж байна.

Холбооны байгууллагууд 1.6 тэрбум төгрөгийн тарифын орлоготой ажилласны 89.1 хувь нь хүн амын үйлчилгээний орлого байна. Өмнөх оны мөн үеэс нийт орлого 13.9 хувиар буурчээ. Цахилгаан холбоо 3.9, Мэдээлэл холбооны орлого 15.6 кабелийн телевизийн орлого 2.2 хувиар өссөн байна. Нийт орлогын 62.5 хувийг үүрэн телефоны орлого бүрдүүлж байна. Интернетийн үйлчилгээний 9 цэг давхардсан тоогоор 6.4 мянган хүнд үйлчилгээ үзүүлжээ.



Худалдаа, үйлчилгээ

Аймгийн худалдаа нийтийн хоолны 619 цэг салбар 19.5 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурсан байна.

Нийт бараа гүйлгээний 39 хувийг хүнсний дэлгүүр, 28.8 хувийг шатахуун борлуулалт, 16.7 хувийг зоогийн газар, 9.9 хувийг барааны дэлгүүр, 3.1 хувийг эм борлуулалтын орлого, 1.5 хувийг контейнерийн орлого, 0.7 хувийг барилгын материалын дэлгүүрийн орлого, 0.2 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого, 0.2 хувийг авто засварын газрын орлого эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс шатахуун борлуулалт, авто засварын газар, ресторан, зоогийн газарийн орлого 4.5 хувиас 12.0 хувиар нэмэгдэж, эм борлуулалтын орлого 34.1 хувиар, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 23.2 хувиар, барилгын материалын дэлгүүрийн орлого 22.3 хувиар, хүнсний дэлгүүрийн орлого 13.2 хувиар, барааны дэлгүүрийн орлого 2.4 хувиар буурчээ. Нийт бараа гүйлгээний 99.2 хувь нь Баян-Өндөр суманд хийгджээ.



Нийтийн аж ахуйн болон ахуйн үйлчилгээ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого 4.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өссөн байна. Нийт орлогын 46.5 хувийг орон сууцны, 43.2 хувийг аж ахуйн нэгж албан газрын, 5.8 хувийг зочид буудлын, 2.3 хувийг хог тээвэрлэлтийн, 1.4 хувийг зөөврийн цэвэр ус борлуулалтын, 0.7 хувийг халуун ус, саун үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс орон сууц, аж ахуйн нэгж албан газрын, саун, халуун ус, хог тээвэрлэлт, зөөврийн цэвэр усны үйлчилгээний орлого 1.4% - 2.2 дахин нэмэгдэн, зочид буудал, иргэдийн үйлчилгээний орлого 7.9 - 58.3 хувиар буурсан байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлогын 99.8 хувийг Баян-Өндөр сум эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний салбарын дүнгээр 386.0 сая төгрөгийн үйлчилгээ явуулж, орлого өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар их байна.

Нийт орлогын 44.9 хувийг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, 34.7 хувийг үсчин, 9.2 хувийг прокат ба тоглоомын цэгийн, 4.0 хувийг гутал засвар, 3.3 хувийг гэрэл зураг, 3.0 хувийг хими цэвэрлэгээ, 0.6 хувийг телевизор засвар, 0.3 хувийг цаг засварын орлого эзэлж байна. Ахуйн үйлчилгээний орлогын 99.8 хувийг Баян-Өндөр сум бүрдүүлдэг ба Жаргалант суманд зөвхөн 1 үсчин үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн зоогийн газрын 111 цэг салбар 3.3 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар үүнээс ресторан, баарны орлого 11.8 хувиар нэмэгдсэн байна. Нийтийн хоолны бараа гүйлгээний 36.9 хувийг ресторан, баарны орлого эзэлж байна.

Он гарсаар сууц өмчлөгчдийн холбоод 284.7 сая төгрөгийн орлого, 265.2 сая төгрөгийн зарлагатай ажиллажээ. Өмнөх оноос орлого 6.7 хувиар, зарлагын хэмжээ 14.7 хувиар нэмэгджээ. Барилгын засвар үйлчилгээний зардалд 47.5 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос мөн үеэс 5.8 хувиар нэмэгдсэн байна. Нийт зардлын 17.9 хувийг барилгын засвар үйлчилгээнд зарцуулжээ.



Бусад мэдээлэл

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур -4.2 хэмийн хүйтэн байж, өмнөх оны мөн үеэс 0.9 хэмээр хүйтэн байна. Хур тунадас өмнөх оны мөн үеэс 1.7 мм-ээр их байна.

Агаарын чанарын MNS4585:2016 стандартад харьцуулан үзэхэд хотын төв орчимд том ширхэгт тоос (PM10) хамгийн их агууламжндаа стандартаас 3.1 дахин, гэр хороолол орчимд Азотын давхар исэл (NO₂) хамгийн их агууламжндаа 1.06 дахин давсан байгаа нь агаарын чанарын индексээрээ бага зэргийн бохирдолтой ангилалд хамрагдаж байна.



Бүртгэл

УБХ-ийн мэдээгээр тайлант хугацаанд 91 аж ахуйн нэгж шинээр байгуулагдан, 12 аж ахуйн нэгж хасагдсанаар бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 4349-д хүрч, өмнөх оноос 1.9 хувиар нэмэгджээ.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлж эхэлсэн энэ хугацаанд хүсэлт гаргасан 20.2 мянган өрхөд 1429.96 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хувьчилж олгосноос 26.56 га газрыг энэ оны 1-р улиралд олгожээ. Газар хүссэн өрхийн хүсэлтийн 90.9 хувийг барагдуулж, газрын төлбөрт 1.9 тэрбум төгрөг буюу 23.4 хувийг төвлөрүүлсэн байна.

Í ÐÍ Í Í ÓÄËÍ Ò ÑÄËÍ Í ÐËÍ Ä , сая төгрөг
BUDGET REVENUE

	2016	2017			2017/2016=%
		Ò ë° äë° ¢° Plan	Äëóýäýë Execution	Äëäýëò Fulfilment	
Í ëëòí ðëí ä	19740.4	18804.4	21276.1	113.1	107.8
Óðñäë í ðëí ä	19740.4	18804.4	21276.1	113.1	107.8
Òàóààòóí í ðëí ä	10970.3	9660.8	12315.6	127.5	112.3
Í ðëí äí í äëááí òàóààò	6950.9	6185.0	7619.2	123.2	109.6
~Õí àí úí í ðëí äí í äëááí òàóààò	6950.9	6185.0	7619.2	123.2	109.6
Yүнээс: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, үрэмшүүлэл		6000.0	7306.6	121.8	
~Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-	-		
Хөрөнгийн албан татвар	1771.7	1511.6	2242.4	148.3	126.6
Óðñäë çí ðëóëäëòóí í ðëí ä					
Áóñää òàóààò	2247.7	1964.2	2454.0	124.9	109.2
Òàóààòóí áóñí ðëí ä	8770.1	9143.6	8960.5	98.0	102.2

Àðèèæàí ù áàí éí ù òääæèè à æ


	Òääæèè à æ (ñàÿ.ø ã)		2017/2016=%	Òääæèè à æÿçÿì ø èã-		2017/2016=%
	2016	2017		2016	2017	
Ãí èí ì ò áàí è	20378.7	27661.7	135.7	7528	8753	116.3
ÕÕÁàí è	27277.1	35045.3	128.5	9626	10656	110.7
Òàà - í áàí è	38624.1	49942.1	129.3	45860	45518	99.3
Òø òèéí áàí è	20612.4	24052.8	116.7	15407	16101	104.5
Òãñ áàí è	31380.1	38354.1	122.2	22632	24134	106.6
Èàí èòàè	3692.3	4264.6	115.5	2405	5430	225.8
Èàí èòðí í	4562.2	7156.2	156.9	2077	2225	107.1
Í ÈÈÒÄ-Í	146526.9	186476.8	127.3	105535	112817	106.9

ЛЭЙ И ЛЛК У З ЛК ЖК У НЛМЛИЛН , СС ИЙ К НШШ

	Н				Н АА
	с				
НЛЛк	0.5	0.7-1.3	0.17	0.35-0.55	0.42-2.5
М	0.6	0.7-1.35	0.17	0.3-0.7	0.42-2.3
Н	0.5	0.85-1.25	0.17	0.4-0.55	0.42-2.2
с	0.6	0.7-1.3	0.20	0.2-0.45	0.42-2.4
Н	0.48	0.82-1.18	0.20	0.25-0.49	0.42-2.5
ж	0.6	0.93-1.39	0.29	0.45-0.67	0.6-2.6
ж	0.6	0.84-1.4	0.25	0.45-0.75	0.42-2.6


Л... Ц...

З...	Л... (Ш...)		Зээлжигчийн тоо		Үүнээс:			
					Иргэд		Аж ахуй нэгж, байгууллага	
	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
М...	4123.8	27956.3	533	652	533	645	-	7
ННЗ...	6233.1	37660.8	578	826	570	820	8	6
Н...	16742.8	85731.2	5859	6300	5858	6298	1	2
С...	8519.6	36719.0	6338	7856	6337	7856	1	-
Н...	5988.0	24060.6	2216	1632	2214	1631	2	1
Ж...	1535.0	8742.9	1179	968	1179	965	-	3
Ж...	2223.6	10632.2	337	478	336	471	1	7
К И С К	45365.9	231503.0	17040	18712	17027	18686	13	26



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс , 2017 оны 03 дугаар сард


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017 III 2016 III	2017 III 2016 XII	2017 III 2017 II
Ерөнхий индекс	100.0	100.3	102.5	100.1
Хүнсний бараа, ундуу , ус	29.3	97.9	109.9	100.9
Согтууруулах ундаа, тамхи	3.2	100.1	100.0	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	104.0	99.5	99.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	97.8	98.9	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	100.1	100.2	99.9
Үй, оёдло, үйлдвэр, үйлчилгээний үйлчилгээ	3.6	99.4	100.3	100.0
Өмчлөх	12.2	100.8	100.8	100.0
Тээвэр, мэдээллийн, өмчлөх үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Ажлаа, үйлдвэр, үйлчилгээний үйлчилгээ	2.8	100.1	100.0	100.0
Ажлаа, үйлдвэр, үйлчилгээний үйлчилгээ	4.7	105.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	97.5	100.0	100.0
Ажлаа, үйлдвэр, үйлчилгээний үйлчилгээ	4.1	103.0	99.4	100.1




Гадаад худалдаа
External trade

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2016	2017	2017/ 2016=%
Нийт эргэлт	тэрбум. төг	366.2	524.6	143.3
	сая.ам доллар	180.8	211.9	117.2
Нийт экспорт <i>Exports, million. tog</i>	тэрбум. төг	313.6	484.8	154.6
	сая.ам доллар	154.8	195.8	126.5
Зэсийн баяжмал	мян.тн	158.4	160.5	101.3
Молибдены баяжмал	мян.тн	1.5	1.7	113.3
Катодын зэс	мян.тн	3.5	4.1	117.1
Хивс	мян.м2	10.9	5.7	52.3
Малын хөлдүү мах	тн	40.0	0.0	-
Тосны ургамал <i>/Rapс/</i>	тн			
Хивэг, хорголжлоогүй	тн			
Нийт импорт <i>Imports. million.tog</i>	тэрбум. төг	52.6	39.9	75.9
	сая.ам доллар	26.0	16.1	61.9
Тээрмийн ган бөмбөлөг	мян.тн	2.2	1.4	1.6дах
Дизелийн түлш	мян.тн	2.5	6.6	2.6дах
Бензин	мян.тн	4.9	4.1	83.7
Улаанбуудай, зөөлөн	мян.тн	2.2	0.0	0.0
Хөх тариа	мян.тн			
Авто машин	ширхэг			

Гадаад худалдаа, тэрбум төгрөг



ЭКСПОРТЫН БАРААНЫ БҮТЭЦ, хувиар



НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР, эдийн засгийн салбарын ангиллаар

1	Үгээр нь үйлчилгээний үйлчилгээний нэр	2016	2017	
			Ажлын байр	үүнээс: шинэ ажлын байр
1	Идэвхтэй ажил	308	98	12
2	ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	7	-	-
3	Уул уурхай, олборлолт	9	-	-
4	Боловсруулах үйлдвэрлэл	41	6	-
5	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3	-	-
6	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2	-	-
7	Барилга	16	-	-
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	27	9	5
9	Тээвэр болон агуулахын үйл ажиллагаа	5	-	-
10	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	11	4	-
11	Мэдээлэл, холбоо	2	-	-
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	12	
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	-	-
14	Мэргэжлийн, шинжлэх ухааны болон техникийн үйл ажиллагаа	12	-	-
15	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	16	-
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	12	23	4
17	Боловсрол	90	21	3
18	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	8	3	-
19	Урлаг, үзвэр, тоглоом наадам	2	-	-
20	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	55	4	-
21	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	-	-	-
22	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	-	-

ÀÆÈÈÄ-É×--ÀÈÈÍ Õ Î

NUMBER OF UNEMPLOYED PERSONS

	2016	2017	2017/2016=%
Бүртгэлтэй ажилгүйчүүд	2422	1751	72.3
<i>Эмэгтэй</i>	1318	966	73.3
Àæèèäé÷çä äí ù áçëäýð			
15-24	516	280	54.3
25-34	1018	739	72.6
35-44	508	390	76.8
45-60	380	342	90.0

НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР

NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK

	2016	2017	2017/2016=%
Áçää	308	98	31.8
<i>Эмэгтэй</i>	197	65	33.0
Õðèéí, ðñ° àò ááéäóèèää	96	57	59.4
Í °ððè°è, èì ì ì áí è	187	33	17.6
Õðø î î	1	-	
Бусад	24	8	33.3


Ø ÈÍ ÝÝÐ Á-ÐÒÄÝÄÄÑÝÍ ÀÆÈÈÄ-É×--Ä

	2016	2017	2017/2016=%
Нэмэгдсэн ажилгүйчүүд	1937	950	49.0
<i>Эмэгтэй</i>	1125	567	50.4
Í ðí í ä î ì ù õì ì õäè è î ñ	259	180	69.5
Ááéäóèèää òààí áóóääñáí ààn	101	31	30.7
° ð äçðääñ ø èèæèèèðýí	211	99	46.9
Ñóðäóèè ð äñ° í	620	211	34.0
Õýðäýñ òàèääñàí	32	8	25.0
Ì ýðäýæèèéí àæèè î èäí òäçéäýñ	6	-	
Òàèèí áàääàèèääñ	102	47	46.1
Áóñää	606	374	61.7

АЖИЛГҮЙЧҮҮД (боловсролоор)

	2016	2017	2017/2016=%
Ажилгүйчүүд - бүгд	2422	1751	72.3
Дээд	864	656	75.9
Тусгай дунд	119	93	78.2
Мэргэжлийн анхан шатны	204	135	66.2
Бүрэн дунд	1127	804	71.3
Суурь	89	48	53.9
Бага	12	10	83.3
Боловсролгүй	7	5	71.4

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН БҮТЭЦ, боловсролоор



ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ

	2016	2017	2017/2016=%
Төрсөн хүүхдийн тоо	562	469	83.5
Нас барсан хүний тоо	148	96	64.9
Бүртгүүлсэн гэр бүлийн тоо	174	129	74.1
Цуцалсан гэр бүлийн тоо	51	40	78.4
Үрчлэгдсэн хүүхдийн тоо	11	16	145.5


ШИЛЖИН ЯВАГСАД

	2016	2017	2017/2016=%
Хүн	846	689	81.4
үүнээс: 0-14 насны	156	190	121.8
насаар 15-54	645	461	71.5
55 ба түүнээс дээш насны	45	38	84.4
Бүгдээс: Улаанбаатар	503	314	62.4
аймгаар Дархан -уул	37	28	75.7
Булган	123	127	103.3
Сэлэнгэ	30	61	2.0 ²
Хөвсгөл	31	28	90.3
Завхан	17	28	164.7

²-Дахин их

ШИЛЖИН ИРЭГСЭД

	2016	2017	2017/2016=%
Хүн	569	678	119.2
үүнээс: 0-14 насны	162	179	110.5
насаар 15-54	353	445	126.1
55 ба түүнээс дээш насны	54	54	100.0
Бүгдээс: Булган	133	169	127.1
аймгаар Улаанбаатар	221	224	101.4
Завхан	22	21	95.5
Хөвсгөл	33	35	106.1
Сэлэнгэ	39	42	107.7
Архангай	30	34	113.3



Үй үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ

	2016	2017	2017/2016=%
Нийт үзлэг, хүн	145868	151465	103.8
Үүнээс: урьдчилан сэргийлэх үзлэг, хүн	45593	46975	103.0
Иргэдэд үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний өдөр	1.55	1.49	95.9
Үйлчилгээний өдөр	5785	5776	99.8
Иргэдэд үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний өдөр	44317	42570	96.1
1 өдөр үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний өдөр	7.66	7.37	96.2
Сэргийлэх тарилга, хүн	4072	4078	100.1
Өөрийн хөрөнгийн өдөр	98.3	98.3	0.0

Өөрийн үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ, ажил үйлчилгээний үйлчилгээ


	Үйлчлүүлсэн хүний тоо		2017/2016=%	Үйлчилгээний орлого (сая.төг)		2017/2016=%
	2016	2017		2016	2017	
Өөрийн үйлчилгээ	202	99	49.0	6.7	4.8	71.6
Өөрийн үйлчилгээний үйлчилгээ	4731	4746	100.3	122.6	107.8	87.9
Ажил үйлчилгээний үйлчилгээ	15027	14755	98.2	473.9	1224.3	2.6 ²
А-1	19960	19600	98.2	603.2	1336.9	2.2²

²-Дахин их

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрлөөр

		2016	2017	2017/2016=%	
Бүртгэгдсэн гэмт хэрэг - бүгд		153	186	121.6	
Үүнээс	~илрээгүй хэрэг	18	22	122.2	
Илрүүлэлтийн хувь		62.5	65.1	2.6	
Бүгдээс: хэргийн өнгөөр	~Хүнийг санаатай алах	1	1	100.0	
	~Хүчиндэх	7	4	57.1	
	~Танхайрах	1	7	7.0 ²	
	~Бусдын бие махбодид гэмтэл учруулах	61	75	123.0	
	~Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг	11	9	81.8	
	~Бусдын эд хөрөнгө хулгайлах	45	56	124.4	
	үүнээс:				
		иргэдийн өмчийн хулгай	40	51	127.5
		малын хулгай	1	3	3.0 ²
	~ Бусдын эд хөрөнгө булаах	-	1		
	~ Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	3	4	133.3	
	~Залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх	13	8	61.5	
	~Албан тушаалын	1	-		
	~ Орчиндоо аюул учруулах амьтныг хамгаалалтгүй байлгах	-	-		
~Бусад	10	21	2.1 ²		
Бүгдээс:	~согтуугаар үйлдэгдсэн	66	83	125.8	
	~хүнд, онц хүнд гэмт хэрэг	16	19	118.8	
	~бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй	48	63	131.3	
Гэмт хэргийн улмаас	~нас барсан хүн	7	4	57.1	
	~гэмтсэн хүн	63	95	150.8	
	~учирсан хохирол /сая.төг/	279.5	351.2	125.7	
	үүнээс:	~иргэдэд учирсан	279.5	351.2	125.7
		~нөхөн төлүүлсэн	205.3	102.1	49.7
~битүүмжилсэн хөрөнгө		2.5	32.0	12.8 ²	
Гэмт хэрэгт холбогдогчид		123	184	149.6	
Үүнээс:	~18 хүртэл насны хүмүүс	2	11	5.5 ²	
	~ажилгүй	79	105	132.9	
	~согтуугаар	61	90	147.5	
	~гэмт хэрэг бүлэглэн үйлдэгч	20	47	2.3 ²	
Эрүүлжигдсэн хүн		1152	1671	145.1	
Захиргааны шийтгэлээр баривчлагдсан		105	97	92.4	
18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг		23.8	27.1	3.2	
Хутгатай холбоотой зөрчил		-	-		
Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон		319	266	83.4	
Эрх хасагдсан		267	241	90.3	

²-Дахин их



Нийгмийн даатгалын үйлчилгээ

(сая.т)

	2016 III	2017 III			$\frac{2017}{2016}=\%$		
		Т	Г	%			
1. Орлогын дүн	14694.3	14371.0	15344.4	106.8	104.4		
Тэтгэвэр	8893.5	8750.8	9373.8	107.1	105.4		
Тэтгэмж	989.3	1063.6	1063.9	100.0	107.5		
ҮОМШӨ	1727.9	1278.7	1767.2	138.2	102.3		
Ажилгүйдэл	263.4	235.8	249.6	105.9	94.8		
Эрүүл мэндийн даатгал	2820.2	3042.1	2889.9	95.0	102.5		
2. Зарлагын дүн	18982.4	18436.4	18726.7	101.6	98.7		
Тэтгэвэрт	12767.8	14207.6	14919.4	105.0	116.9		
Тэтгэмж	3730.9	1165.7	1017.4	87.3	27.3		
Эрүүл мэндийн даатгал	1271.7	1660.6	1448.7	87.2	113.9		
ҮОМШӨ	961.0	1123.0	988.5	88.0	102.9		
Ажилгүйдэл	251.0	279.5	352.7	126.2	140.5		
3. Тэтгэвэр авагчдын тоо	13197	х	14357	х	108.8		
Үүнээс:	~өндөр нас	9140	х	10257	х	112.2	
	~хөгжлийн бэрхшээлтэй иргэн	3146	х	3221	х	102.4	
	~тэжээгчээ алдагч	911	х	879	х	96.5	
Бүгдээс	Тухайн сард тэтгэврийн мөнгөө авсан хүний тоо	13191	х	14357	х	108.8	
	Үүнээс:	~өндөр нас	9137	х	10257	х	112.3
		~хөгжлийн бэрхшээлтэй иргэн	3145	х	3221	х	102.4
		~тэжээгчээ алдагч	909	х	879	х	96.7
4. Тэтгэвэр тогтоогдсон хүний тоо	391	х	404	х	103.3		
Үүнээс:	~өндөр нас	255	х	256	х	100.4	
	~хөгжлийн бэрхшээлтэй иргэн	110	х	133	х	120.9	
	~тэжээгчээ алдагч	26	х	15	х	57.7	

		2016 III	2017 III	$\frac{2017}{2016}=\%$
AA		72091	71585	99.3
AA		45755	44205	96.6
		26336	27380	104.0
с AA		36214	37025	102.2

Нийгмийн халамжийн үйлчилгээ

	Хүний тоо		2017 2016%	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж (сая.т)		2017 2016%
	2016 III	2017 III		2016 III	2017 III	
Халамжийн тэтгэвэр	1799	1675	93.1	666.2	679.5	102.0
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1725	1819	105.4	291.2	326.7	112.2
ахмад настныг асарч буй иргэнд	873	931	106.6	146.1	164.4	112.5
